

2017 ОНЫ 7 ДУГААР САРД БОЛСОН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2017.07.28

Шарга сум

ЖИЛ БҮРИЙН 8 САРЫН 20-ООС ӨМНӨ ХАРМАГ ТҮҮЖ БЭЛТГЭХИЙГ ХОРИГЛОНО

Сумын Засаг даргын 2017 оны 07 сарын 17-ны өдрийн А\34 тоот захирамжаар жил бүрийн 8 сарын 20-оос өмнө хармаг түүж бэлтгэхийг хориглосон захирамж гаргалаа. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ард иргэдэд сурталчлахаас гадна байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар хяналт тавьж эргүүл шалгалтын ажлыг хийж байна.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ИРГЭДЭД ЗЭЭЛ ОЛГОЖ БАЙНА

Сумын ИТХ-аар сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийг шинэчлэн баталсан. Мөн иргэн, аж ахуйн нэгжид өгөх зээлийг хэмжээг өөрчилсөн. Сум хөгжүүлэх санд ирүүлсэн төслийг сар бүр төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлаар хэлэлцэж дэмжигдсэн зээлүүдийг санхүүжүүлж байна. Энэ онд 10 иргэнд 26.2 сая төгрөгийн зээлийг журмын дагуу олгоод байна. Зээлээ зориулалтын дагуу зарцуулаагүй, төлбөрөө хугацаанд нь төлөөгүй 8 иргэнд мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн.

АЙМГИЙН АРСЛАН ЦОЛТОН 1, НАЧИН ЦОЛТОН 2 ТӨРЛӨӨ

Ардын хувьсгалын 96 жилийн сумын баяр наадамд аймгийн заан Э.Даваажаргал түрүүлж, залуу бөх Ч.Бат-Эрдэнэ үзүүрлэлээ. Цолгүй 32 бөхийн барилдаанд Т.Ариунболд түрүүлж Т.Мягмарзаяа үзүүрлсэн. Сумын Засаг даргын 2017 оны А\35 дугаар захирамжаар Т.Ариунболд, Т.Мягмарзаяа, Ч.Бат-Эрдэнэ нарт сумын начин цол хүртээлээ. Мөн Говь-Алтай аймгийн үндэсний баяр наадамд сумын заан Б.Төрмөнх үзүүрлэж аймгийн начин, Налайх дүүргийн баяр наадамд тус сумын харъяат бөх Э.Даваажаргал аймгийн арслан, Э.Өвгөнхүү аймгийн начин цолыг тус тус хүртлээ. 8 сарын 07-ны өдөр аймгийн арслан Э.Даваажаргалын цолны мялаалга наадам болно.

Мэдээ бэлтгэсэн: Д.Ончимэг